

**ШИНЭ МОНГОЛ  
ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2026 оны 05 сарын 10 өдөр

Дугаар

A/12

Улаанбаатар хот

**Тэтгэлэг, кредитийн урамшуулал олгох  
журам батлах тухай**

“Дээд боловсролын тухай хууль”, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 215 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. 2026-2027 оны хичээлийн жилээс эхлэн Шинэ монгол технологийн их сургуульд бакалавр, магистрын сургалтын үйл ажиллагаанд “Тэтгэлэгийн журам, кредитийн урамшуулал олгох журам”-ыг баталсугай.
2. 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн А/26-1 тоот тушаалыг хүчингүй болгосугай.
3. Тэтгэлэг, кредитийн журмыг 2026 оны 06 сарын 02-оос эхлэн дагаж, мөрдөн ажиллахыг Сургалтын албаны мэргэжилтэн Ж.Эрдэнэчимэг хяналт тавихыг Чанарын албаны менежер М. Энхтуул-д тус тус үүрэг болгосугай.
4. Сургалтын тэтгэлийг зохих журмын дагуу бүртгэл тооцоо хийхийг нягтлан бодогч Б. Мөнхзул -д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ

Д. ГАНТУУЛ



ШМТИС-ийн Захирлын 2026 оны 05 сарын 29-ны  
өдрийн .../... тоот тушаалын  
Хавсралт 1



## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Шинэ Монгол Технологийн Их Сургууль (цаашид ШМТИС гэх)-ийн тэтгэлэг, кредитийн урамшууллын журмын зорилго нь бакалавр, магистрын хөтөлбөрүүдэд элсэн суралцагч болон амжилттай суралцаж буй тэргүүний суралцагчдыг дэмжин урамшуулах, суралцах чин хүсэл, эрмэлзэлтэй шилдэг элсэгчдэд дэмжлэг үзүүлэхэд оршино.
- 1.2. Энэхүү журмаар ШМТИС-ийн суралцагчид болон элсэгчдэд тэтгэлэг олгох, тэтгэлгийг үргэлжлүүлэх, цуцлах харилцааг зохицуулна.

## ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1. Энэхүү журам нь ШМТИС-д бакалавр, магистр, докторын түвшний хөтөлбөрт суралцаж буй суралцагчид болон шинээр элсэгчдэд хамаарна.
- 2.2. Тус журам нь тэтгэлэг, кредитийн урамшуулал авах болзол хангасан суралцагчийн материал хүлээн авах, шалгаруулах, олгох үйл явцыг хамарна.

## ГУРАВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 3.1. Тэтгэлэг гэж ШМТИС-ийн суралцагчдад сургалтын төлбөр болон бусад төлбөрөөс чөлөөлөх хэлбэрээр олгодог санхүүгийн дэмжлэгийг хэлнэ.
- 3.2. Кредитийн урамшуулал гэж сурлагын болон эрдэм шинжилгээ, урлаг, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, амжилт гаргасан суралцагчдад сургалтын багц цагийн урамшуулал хэлбэрээр олгодог санхүүгийн дэмжлэгийг хэлнэ.

## ДӨРӨВ. ТЭТГЭЛГИЙН ТӨРӨЛ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 4.1. ШМТИС-ийн тэтгэлэг, урамшуулал нь дараах төрлүүдтэй байх бөгөөд тэтгэлэгийн хувь хэмжээг тусгав. Үүнд:

- 4.1.1. Элсэгчдэд олгох тэтгэлэг:

- Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангид суралцаж байхдаа математик, физик, хими, биологи, мэдээлэл зүй, техник технологийн чиглэлээр олон улс, улс, аймаг, нийслэлийн олимпиадад оролцож медальт байр эзэлсэн тохиолдолд эхний жилийн сургалтын төлбөрөөс доорх хувь хэмжээтэй тэнцэх тэтгэлэг олгоно:
  - Байгалийн ухаан, техник технологийн Улсын олимпиадын алт, мөнгө, хүрэл – 100%;
  - Аймаг, Нийслэлийн олимпиадын алт, мөнгө, хүрэл – 75%;
  - Дүүргийн олимпиадын алт, мөнгө, хүрэл – 50%;
  - Байгалийн ухаан, техник технологийн Улсын олимпиад тусгай байр – 50%;
- Элсэлтийн ерөнхий шалгалт (ЭЕШ)-ын өндөр оноотой элсэгчдэд эхний жилийн сургалтын төлбөрөөс доорх хувь хэмжээтэй тэнцэх тэтгэлэг олгоно:
  - 750-800 оноотой бол 100%;
  - 700-749 оноотой бол 75%;
  - 650-699 оноотой бол 50%;
  - 600-649 оноотой бол 30%;



ШМТИС-ийн Захирлын 2026 оны 05 сарын 20-ны өдрийн ~~...~~ тоот тушаалын Хавсралт 1

- “ҮНДЭСНИЙ ТЭТГЭЛЭГТ СОРИЛГО – SCIENCE CHALLENGE”-ийг шилдэг оролцогчдоод олгох тэтгэлэг:

- Нийт оролцогчдоос 95%-иас дээш гүйцэтгэлтэй эхний 5 сурагчид – 100%;
- Ангилал бүрийн 6-10 дахь сурагчдад – 50%;
- Дараагийн 11-16 дахь сурагчдад – 40%;
- Дараагийн 17-22 дахь сурагчдад – 30%;
- Дараагийн 23-28 дахь сурагчдад – 20%;
- Дараагийн 29-34 дэх сурагчдад – 10%;

- ШМЭХ-ийн харьяа бүрэлдэхүүн сургуулиас бакалаврын өдрийн ангийн хөтөлбөрт элсэгчдэд олгох тэтгэлэг /Эхний семестр/:

- Ерөнхий боловсролын Шинэ Монгол сургууль – 20%;
- Ерөнхий боловсролын Шинэ Монгол Харумафүжи сургууль – 20%;
- Шинэ Монгол технологийн коллеж – 20%;
- Ерөнхий боловсролын Шинэ Монгол-3 сургууль – 20%;

#### 4.1.2. Суралцагчдад олгох тэтгэлэг (Бакалавр, Магистр, Доктор):

- Сүүлийн хоёр улирал дараалан багадаа 15 кредитийн хичээлийг сонгон судалсан байх шаардлагатай бөгөөд сүүлийн улирлын үнэлгээний голч дүн нь 3,5-аас дээш суралцсан бакалаврын түвшний суралцагчид хичээлийн жилийн 2-р улиралд доорх тэтгэлгийг олгоно:

- 3.9 - 4.0 голч дүнтэй бол – 40%;
- 3.8 - 3.89 голч дүнтэй бол – 35%;
- 3.7 - 3.79 голч дүнтэй бол – 30%;
- 3.6 - 3.69 голч дүнтэй бол – 25%;
- 3.5 - 3.59 голч дүнтэй бол – 20%;

- Энэхүү журмын 4.1.1-д заасан нөхцөлөөр тэтгэлэг авсан элсэгч нь цаашид тэтгэлгээ үргэлжлүүлэн ашиглахын тулд сурлагын амжилтаа тогтмол хадгалах үүрэгтэй. Хэрэв суралцагчийн тухайн улирлын үнэлгээний голч дүн 3.0-аас доош буурвал тэтгэлэг олгохгүй. Харин дараагийн аль нэг улиралд 3.5-аас доошгүй голч дүнтэй суралцсан тохиолдолд тэтгэлэг авах эрх нь дахин сэргэнэ.

- Магистрын хөтөлбөрт элсэн суралцагчдад олгох тэтгэлэг:

- ШМТИС-ийн бакалаврын төгсөгч элсэн тохиолдолд – 20% хүртэл;
- Салбар сургуулийн багш нар суралцсан тохиолдолд – 20%;
- ШМТИС-ийн ажилтан болон тэдний гэр бүлийн хүн суралцсан тохиолдолд – 30%;
- Хамтын ажиллагааны гэрээтэй байгууллагын ажилтнуудад олгох тэтгэлгийг захирлын гэрээгээр тогтооно;

- Олон улсын олимпиад болон мэргэжлийн уралдаан тэмцээнд амжилттай оролцоход олгох тэтгэлэг:

- Олон улсын олимпиадын алт, мөнгө, хүрэл медаль – 100%;

ШМТИС-ийн Захирлын 2026 оны 05 сарын 29-ны  
өдрийн ~~ММ~~ тоог тушаалын  
Хавсралт 1



- Олон улсын мэргэжлийн уралдаан тэмцээн – Багаар 3,000,000 /Турван сая төгрөг/-ийн урамшуулал;

#### 4.1.3. Урлаг, спорт, олон нийтийн амжилтад олгох урамшуулал:

- Сургуулийн нэр дээр Улсын болон Олон улсын чанартай урлаг, спортын тэмцээнд /Олимпийн төрөл/ амжилт (1-3-р байр) гаргасан тохиолдолд захирлын шийдвэрээр 3 хүртэлх кредиттэй тэнцэх сургалтын төлбөрийг дараагийн улиралд хөнгөлнө.
- Оюутны зөвлөл болон сургуулийн олон нийтийн үйл ажиллагаанд манлайлан оролцсон шилдэг оюутанд захирлын шийдвэрээр 3 хүртэлх кредиттэй тэнцэх сургалтын төлбөрийн хөнгөлөлт олгож болно.

#### 4.1.4. Сургалтаас гадуурх сургуулиас зохион байгуулж буй үйл ажиллагаанд оролцсон урамшуулал

- Оюутан тухайн хичээлийн жилд оюутан хөгжлийн албанаас зохион байгуулсан бүх үйл ажиллагааны ирц 70 хувиас дээш хамрагдсан байх;
- Оюутны үйл ажиллагаанд оролцсон ирцийн бүртгэлийг оюутан хөгжлийн баг бүртгэн баталгаажуулна;
- Хичээлийн жилийн төгсгөлд оюутан тус бүрийн үйл ажиллагаанд оролцон тайланг оюутан хөгжлийн баг тайлагнаж шаардлага хангасан оюутанд кредитийн урамшууллыг олгох тушаал гаргуулна;
- Кредитийн урамшууллын шийдвэрийг захирлын тушаалаар баталж 3 хүртэлх кредитийн урамшуулал олгоно.

#### 4.1.5. Тэтгэлэг үргэлжлүүлэх нөхцөл:

- 4.1.1-д заасан нөхцөлөөр тэтгэлэг авсан элсэгч нь тухайн тэтгэлгийг зөвхөн эхний хичээлийн жилд (2 улирал) ашиглах эрхтэй.
- Элсэгч эхний улиралдаа 2.8-аас доош голч дүн авбал дараагийн улирлын тэтгэлэг олголтыг зогсооно.
- Тэтгэлэг авсан элсэгч нь 2 дугаар курст орохдоо (3 дугаар улирлаас эхлэн) энэхүү журмын 4.1.2-т заасан "Сурлагын амжилтын тэтгэлэг"-ийн ерөнхий шатлалд шилжиж, тухайн улирлын голч дүнгээрээ тэтгэлэг авах эрхтэй.
- ШМТИС-ийн үндсэн багш, ажилтны хүүхэд суралцаж буй бол ажилласан жил, амжилт, цаашдын төлөвлөлтөөс хамааран Менежментийн зөвлөлийн шийдвэрээр төлбөрийн хөнгөлөлт олгоно.

4.2. ШМТИС-ийн суралцагч нь Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 215 дугаар тогтоолоор батлагдсан Боловсролын зээлийн сангийн тэтгэлэг, оюутан хөгжлийн зээлд хамрагдах боломжтой бөгөөд тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж авахад тавигдах нийтлэг шаардлага болон бүрдүүлэх материалыг Засгийн газрын холбогдох журмын 2.1 болон 3.1-д заасны дагуу баримтална.

### **ТАВ. ТЭТГЭЛГИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ, МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ**

- 5.1. Элсэгчийг дэмжих тэтгэлэгт нэр дэвшигч нь элсэх эрхийн бичгээ авсны дараа элсэлтийн бүртгэлийн хугацаанд багтааж амжилтыг нотлох бичиг баримтыг Сургалтын албанд ирүүлнэ.
- 5.2. Сурлагын амжилтын тэтгэлэгт нэр дэвшигч нь дараах материалыг бүрдүүлнэ:



- Тэтгэлэг хүссэн өргөдлийн маягт /Сургалтын алба, Тэнхимийн эрхлэгч, Захирлын гарын үсэг/;
- Судалсан хичээл, дүнгийн баталгаажуулсан жагсаалт /XCloud системээс/;
- Амжилт гаргасныг нотлох баримтууд /Ох хувийг авч баталгаажуулах/;
- Бүрдүүлэх материалын хичээлийн улирал эхэлсэнээс хойш 3 дугаар 7 хоногын дотор материалыг бүрдүүлж сургалтын албанд өгөх;

### ЗУРГАА. ШИЙДВЭР ГАРГАХ

- 6.1. Тэтгэлэг, урамшууллын хувь хэмжээг Менежментийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж, ШМТИС-ийн Захирлын тушаалаар баталгаажуулна.
- 6.2. Сургалтын алба нь нэр дэвшигчдийн материалыг хүлээн авч, шалгуур хангасан байдлыг хянан, шийдвэрийн төслийг Менежментийн зөвлөлд танилцуулах үүрэгтэй.
- 6.3. Тэтгэлэгийн сонгон шалгаруулалтыг Менежментийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж, эцэслэн шийдвэрлэнэ.
- 6.4. Энэхүү журмаар зохицуулагдах боломжгүй асуудлыг холбогдох хууль, эрх зүйг үндэслэн Менежментийн зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ.
- 6.5. Тэтгэлэг олгох шийдвэрийг хичээлийн улирал бүрийн 4 дүгээр 7 хоногт менежментийн хурлаар хэлэлцэж захирлын тушаалаар баталгаажуулна.

### ДОЛОО. БУСАД

- 7.1. Тэтгэлэгт шалгарсан суралцагчдын нэрсийг улирал тутамд нэгдсэн байдлаар гаргаж, Захирлын тушаалаар баталгаажуулна.
- 7.2. Кредитийн урамшууллыг улирал бүрийн хичээл сонголтоос өмнө баталгаажуулж, сургалтын төлбөрт шилжүүлэн тооцно.
- 7.3. Суралцагч хэд хэдэн тэтгэлэг, урамшууллын болзол хангасан тохиолдолд торол заалтыг давхцуулан олгохгүй бөгөөд зөвхөн хамгийн өндөр хувьтай эсвэл суралцагчийн өөрийн сонгосон нэг хэлбэрийн тэтгэлэг, урамшууллыг олгоно.

### НАЙМ. ХАВСРАЛТ

- 8.1. Тэтгэлэгийн үйл ажиллагаанд шаардагдах баримт бичгүүд

#### Хүснэгт 2

№	Маягтын индекс	Баримт бичгийн нэр	Үе шат	Хариуцах нэгж / албан тушаал	Тайлбар
1	26-SCI-NMIT-01	Тэтгэлэгийн үйл үйл явцын зураглал	Журам шинэчлэгдэхэд	Сургалтын алба	Процессын зураглал
2	26-SCI-NMIT-02	Тэтгэлэг хүсэх өргөдлийн маягт	Журам шинэчлэгдэхэд	Сургалтын алба	